



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/259

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.42 дахь заалт, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.2 дахь заалтыг хэрэгжүүлэх, үндэсний өв соёлоо дэлхийд сурталчлах, хамгийн олон бий биелээчидтэйгээр Геннисийн номонд бүртгүүлэх, бүжгийн урлагаар дамжуулан гоо зүйн боловсрол олгох, ахмад үеэс бий биелгээний үндсэн намба төрхийг суралцах, өвлөх, түгээн дэлгэрүүлэх, хүүхэд, залуучууд, иргэдийн нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлэх зорилгоор зохион байгуулж буй бий биелэгээний "Алтан өв" III наадмын зардалд 6500000 төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх үйл ажиллагаанд шаардагдах 6500000 төгрөг /Зургаан сая таван зуун мянган / -ийг Хөшөөт хөгжил сангийн төсөл, арга хэмжээний 2018 оны төсвийн тодотголоор батлагдсан 4.6 дахь заалтад тусгагдсан зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ -д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Даваадорж/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Зах А/259 Сн
02 01291